

## **“МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БҮРТГЭХ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ”-ЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Мэргэжлийн боловсрол, сургалтыг чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд шилжүүлэх шинэчлэлийг Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлж эхлээд нилээдгүй хугацаа өнгөрч байна.

Монгол улсын хэмжээнд 2016 оны 11 сараас өмнө 2000, 2017-2018 оны өнөөгийн байдлаар Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа 800-аад сургалтын байгууллагыг бүртгэж гэрчилгээжүүлсэн болно.

Журмыг шинэчлэх үндэслэл, шаардлага нь Засгийн газрын 2018 оны 110 дугаар тогтоолоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан нэгжийн орон тоог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шилжүүлсэнтэй холбогдуулан журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байсан Төрийн захиргааны байгууллагын /агентлаг/ чиг үүргийг Төрийн захиргааны төв байгууллага /яам/-д шилжүүлсэн нь “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ыг шинэчлэн боловсруулах шаардлага зайлшгүй гарч байгаа юм.

Журамд иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж, бухимдуулж байгаа зарим бүрдүүлэх бичиг баримтыг хасаж журмын төслөө боловсруулсан болно. /Жич: “ХАБЭА-н шаардлага хангасан” талаарх бичгийг ямар байгууллагаас дүгнэлт авах нь тодорхой бус. МХЕГ-ийн даргын 2011 оны 20 дугаар тушаалаар “Ажлын байрны тухай” дүгнэлт гаргахыг бүр мөсөн зогсоосон, мөн шүүх, татвар, банк, эрүүл мэнд, нийгмийн даатгалын лавлагаа, тодорхойлолтууд./

Монгол улсын хэмжээнд 2017 он хүртэл мэргэжлийн сургалтаар ур чадвар, чадамж эзэмшин төгссөн төгсөгчдөд олон хувилбараар гэрчилгээ, үнэмлэх олгогдож байсан бол одоо Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв байгуулагдсанаар бүх төгсөгчдөд тухайн ур чадвар, чадамжийг эзэмшсэнийг гэрчлэх “Чадамжийн гэрчилгээ” олгогдож байна.

Энэхүү журмаар 2016 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/150 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн нэр индекс”-тэй нийцүүлэн Төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв болон Бүсийн арга зүйн төвүүдийн ажлыг уялдуулан шинэчилсэн болно.

Журмын төсөл батлагдсанаар мэргэжлийн сургалтын байгууллагуудын сургалтын чанар болон төгсөгчдийн ур чадвар сайжирч, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодитой үр дүн гарах болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 9 дүгээр сарын .....өдрийн  
.....тушаалын нэгдүгээр хавсралт

## **“МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БҮРТГЭХ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ”**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах нэгж буюу бүлэг ажилбарыг гүйцэтгэх арга барил, техник, технологийн анхан шатны мэдлэг, чадвар, дадлыг тодорхой ажил мэргэжлийн суурь чадвар, чадамжийн хүрээнд эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох богино хугацааны мэргэжлийн сургалтыг /цаашид “сургалт” гэх/ зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулна.

1.3. Энэхүү журмын хүрээнд тодорхой түвшний ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар олгох сургалт эрхлэх байгууллагуудын үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1.3.1. Иргэнд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын төрөлд мэргэжлийн болон техник технологийн суурь чадамж эзэмшүүлэх сургалтууд хамаарна.

1.3.2. Иргэнд хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтад хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох, аж ахуй, бизнес эрхлэх чадамж олгоход чиглэгдсэн сургалтууд хамаарна.

1.4. Энэхүү журмын 3.1-т заасан шаардлагыг ханган бүртгүүлсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж зохион байгуулна.

1.5. Шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэж, улсын хэмжээнд нэгдсэн загвартай, бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээ олгоно.

1.6. Журмын хэрэгжилтийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн зохион байгуулна.

1.7. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг бий болгон баяжуулж, мэдээллийг түгээнэ.

1.8 Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь мэргэжлийн сургалтаар төгсөгчдийн мэдээллийн нэгдсэн санг бий болгон баяжуулж, мэдээллийг түгээнэ.

### **Хоёр. Мэргэжлийн сургалтын зорилго, хамрах хүрээ**

2.1. Мэргэжлийн сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн суурь ур чадвар, чадамж эзэмшүүлэхэд оршино.

2.2 Сургуулиас гадуурх мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагааны чиглэлээр:

2.2.1 Боловсрол /хэл; компьютер; бага, дунд боловсролын стандартын хэрэгжилтийг хангуулах, ахиулах; элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх сургалтууд, өдөр өнжүүлэх үйлчилгээ/;

2.2.2 Соёл, урлаг;

2.2.3 Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал;

2.2.4 Санхүү, бизнес, худалдаа;

2.2.5 Мэдээллийн технологи;

2.2.6 Шуудан, харилцаа холбоо;

2.2.7 Байгаль орчин, аялал жуулчлал;

2.2.8 Барилга;

2.2.9 Тээвэр;

2.2.10 Эрчим хүч;

2.2.11 Уул уурхай;

2.2.12 Хөдөө аж ахуй;

2.2.13 Аж үйлдвэр;

2.2.14 Хот байгуулалт, тохижилт;

2.2.15 Үйлчилгээ;

2.2.16 Эрүүл мэнд /йога, бариа засал/ салбаруудын I-II түвшний мэргэжлийн суурь чадвар олгох сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр явуулна.

2.3. Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу зохион байгуулагдах шашны сургалт болон шашинтай холбоотой зан үйл, холбогдох сургалт үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулахгүй.

### **Гурав. Мэргэжлийн сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

3.1 Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлтээ гаргасан /шинээр/ төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулсан хуулбар/

3.1.2. хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг ажил олгогчийн хэрэгцээнд үндэслэн боловсруулсан байх;

3.1.3. үйл ажиллагаа эрхлэх байршил, хаягийг захирлын тушаалаар баталгаажуулсан байх;

3.1.4 мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв, эсвэл мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвөөр мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг батлуулсан байх;

3.1.5. мэргэжлийн сургалтын төвийн багш нь мэргэжлийн зэрэгтэй, тухайн чиглэлээр 3-аас доошгүй жилийн ажлын дадлага, туршлагатай, мэргэжлийн боловсрол, сургалтын заах арга зүйн сургалтад хамрагдаж, багшлах эрх авсан байх;

3.1.6. мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт заагдсан, мэргэшлийн түвшний шаардлагад нийцсэн сургалтын орчин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх;

3.1.7. өөрийн байранд дадлага хийлгэх боломжгүй тохиолдолд байгууллага аж ахуйн нэгж, үйлдвэрийн газартай гэрээ байгуулж, дадлагын сургалт зохион байгуулах боломж бүрдүүлсэн байх;

3.1.8. мэргэжлийн сургалтын байгууллага нь элсэгчдийн болон төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтын материалыг боловсруулсан байх;

3.1.9. мэргэжлийн сургалтын байгууллага нь суралцагчидтай байгуулах гэрээний загварыг боловсруулан баталгаажуулсан байх;

3.1.10. мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын төлбөрийн хэмжээг гэрээнд тусгасан байна.

3.2. Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь дараах бичиг баримт, тайланг ирүүлсэн байна. Үүнд:

3.2.1. сургалтын төвийн үйл ажиллагааны тайлан;

3.2.2. нийт төгсөгчдийн мэдээлэл;

3.2.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвөөс суралцагчдыг үнэлсэн үнэлгээний жагсаалт;

3.2.4 хугацаа дууссан гэрчилгээний эх хувь;

3.2.5 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргасан албан бичиг.

### **Дөрөв. Мэргэжлийн сургалтын агуулга, стандарт, хөтөлбөр**

4.1. Мэргэжлийн сургалтын агуулга нь I-II түвшний ур чадвар эзэмшүүлэхэд зориулан боловсруулсан чадамжийн нэгжээс бүрдсэн, суралцагч сонгон суралцах боломжийг хангасан байна.

4.1.1. Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн суурь мэдлэг, ур чадвар шаардсан хязгаарлагдмал хүрээнд энгийн ажил үүрэг гүйцэтгэх чадвартай, мэргэжлийн үйл ажиллагаа нь зааварлагчийн шууд удирдлага дор тодорхой нөхцөлд хэрэгжих, нэг төрлийн ажил гүйцэтгэх болон хүнд ажилбаруудыг бусдын удирдлага дор туслах үүргийг хүлээдэг, уг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг тодорхой түвшинд эзэмшиж, мэргэжлийн ур чадвар, олгохоор боловсруулагдсан байна.

4.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь сургалтын хөтөлбөрийг энэхүү журмын 4.1.1 дэх заалтын агуулгын хүрээнд хянаж, 30 хоногийн дотор сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргана.

### **Тав: Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох**

5.1. Мэргэжлийн сургалтын байгууллагаар бүртгүүлэхээр хүсэлт гаргаж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь энэхүү журмын 3.1 дэх заалтыг хангасан байна.

5.1.1. Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлтээ гаргасан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь энэ журмын 3.1; мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх хугацаа сунгуулах хүсэлт гаргасан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь 3.2 дахь заалтын дагуу материалыг бүрдүүлж, тухайн оны 1, 3, 5, 7, 9, 11 дүгээр сарын эхний 10 хоногт Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.1.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ирсэн хүсэлтийг хүлээн авч, орчны стандартыг хангасан эсэхэд дүгнэлт гаргана.

5.1.3. Энэхүү журмын 3.1, 3.2 дахь заалтын дагуу бүрдүүлсэн материалыг хүлээн авсанаас хойш ажлын 21 хоногт багтаан шийдвэрийг [www.mlsr.gov.mn](http://www.mlsr.gov.mn) сайтан дээр байршуулна.

5.1.4. Шаардлага хангаагүй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид утсаар хариу мэдэгдэнэ.

5.1.5. Шаардлага хангаагүй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь дахин хандах тохиолдолд нэмэлтээр дутуу материалаа бүрдүүлж, албан бичгийн хамт Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандана. /хүлээн авсан өдрөөс эхлэн хариу өгөх огноог гаргана/.

5.1.6. Шаардлага хангасан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2; Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолд заасан хураамжийг төлсний дараа гэрчилгээг олгоно.

5.1.7. Шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээг 2, 4, 6, 8, 10, 12 дугаар сарын сүүлийн 10 хоногт Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

5.1.8. Мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа болон төгсөгчдийн мэргэжлийн ур чадварт мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвөөр үнэлгээ хийлгэх хүсэлт гарган, үнэлгээ хийлгэж, эзэмшсэн ур чадварыг баталгаажуулан төгсөгчдөд чадамжийн гэрчилгээ олгоно.

### **Зургаа. Мэргэжлийн сургалтын байгууллагын гэрчилгээний хүчинтэй хугацаа, эрх сунгах, хүчингүй болгох**

6.1. Мэргэжлийн сургалтын байгууллагад олгох гэрчилгээ нь улсын хэмжээнд нэгдсэн загвартай байх, бүртгэлийн он, сар, өдөр, дугаар болон хүчинтэй хугацааг заасан байна.

6.1.1. Мэргэжлийн сургалтын байгууллагад олгох гэрчилгээний дугаар давхцахгүй байна.

6.1.2. Анх удаа хүсэлт гаргаж, шаардлага хангасан сургуулиас гадуурх мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид нэг (1) жилээр, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусч, эрх сунгах хүсэлт гаргасан шаардлага хангасан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хүчинтэй хугацаа хоёр (2) жил хүртэл хугацаагаар олгоно.

6.1.3 Мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.1.4 Мэргэжлийн сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.1.5 Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангаагүй, бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссан, сунгалт хийгдээгүй сургалтын үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас зөрчлийг арилгуулах, сануулах, хариуцлага хүлээлгэх, ажил сайжруулах, түр хугацаагаар үйл ажиллагааг түдгэлзүүлэх, бүртгэлийн гэрчилгээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

### **Долоо: Удирдлага, зохион байгуулалт**

7.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэн гэрчилгээжүүлж, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулна.

7.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв болон мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв нь мэргэжлийн сургалтын байгууллагад мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, дэмжиж ажиллана.

7.3. “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангана.

### **Найм: Тайлан мэдээ**

8.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын мэдээллийн санд улирал бүрт өөрчлөлтийг хийж байна.

8.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны талаарх тайланг хагас, бүтэн жилээр гарган, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангана.

### **Ес: Хяналт**

9.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв болон бүсийн арга зүйн төв нь дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Үүнд:

9.1.1 сургалтын хөтөлбөрийн дүгнэлт;

9.1.2 багшид тавигдах шаардлага;

9.1.3 сургалтын орчны стандарт;

9.1.4 үнэлгээний шалгуур үзүүлэлт;

9.1.4 төгсөлтийн болон хөндлөнгийн үнэлгээ;

9.1.4 төгсөгчдийн ажил эрхлэлт.

9.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь мэргэжлийн зөвлөлөөрөө сайн дурын үндсэн дээр мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг хэлэлцүүлж мэргэжлийн сургалтын байгууллагад дүгнэлт, тодорхойлолт гаргахад хамтран ажиллаж болно.

9.3 Сургалтын үйл ажиллагаатай танилцах явцын үзлэгийг шаардлагатай тохиолдолд тухай бүрт нь хийж болно.

9.4 Мэргэжлийн сургалтын байгууллагыг 2 жилд 1 удаа мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн салбарын мэргэжлийн холбоодтой хамтран хяналт шинжилгээ, үнэлгээ хийж /аттестатчлал/ дүгнэлт гаргана.

9.5 Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

-----o0o-----

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 9 дүгээр сарын .....өдрийн  
.....тушаалын хоёрдугаар хавсралт



**ХӨДӨЛМӨР  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

## **МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

.....оны .... сарын ....өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Шийдвэрийн дугаар: .....

**Аймаг, хот:**

**Сургалтын байгууллагын нэр:**

**Сургалтын төрөл:**

**Байгууллагын хаяг:**

**Удирдах хүн, Утас:**

**Хүчинтэй хугацаа:**

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ  
ГАЗРЫН ДАРГА

...../ /

/Гарын үсэг/

/Нэр/